



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМ



ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ

**ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, УВС АЙМГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ”
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2023 он

АГУУЛГА

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	3
1 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	4
1.1 Эд хөрөнгийн нөхөн олговрыг бүрэн олгох	5
1.2 Улиаст багийн төвийн зураг төслийн ажил	7
1.3 Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах	8
2 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	10
2.1 Соёлын биет бус өв буюу Угсаатан зүйн авран хамгаалах тандалт судалгаа	11
2.2 Соёлын биет өвийн авран хамгаалах малтлага судалгаа.....	11
3 орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /түр замын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ/ 16	
4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ.....	17
4.1 Соёлын биет өвийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг зохион байгуулах 18	
4.2 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэл ажил 18	
4.3 Төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрт олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөний судалгаа хийх	18
4.4 Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумдын ИНХ төлөөлөгчид болон нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, малчид	19
5 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	4
Хүснэгт 2. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10
Хүснэгт 3. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эрх шилжүүлсэн албан бичиг.....	5
Зураг 2. Нэг удаагийн нөхөн төлбөр аймаг руу шилжүүлэхийг хүссэн баримт	6
Зураг 3. Улиаст багийн төвийн ерөнхий төлөвлөгөө.....	7
Зураг 4. Цэцэрлэгийн зохион байгуулалт, Захиргааны байрны зохион байгуулалт	7
Зураг 5. Сургуулийн гадаад байгуулалт, Үйлчилгээний төвийн зохион байгуулалт	7
Зураг 6. Харагдах байдал.....	8
Зураг 7. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн ерөнхий төлөвлөгөө	9
Зураг 8. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн харагдах байдал	9
Зураг 9. Булшны өндөршилтийг харуулсан зураг.....	12
Зураг 10. Чулуун хайрцгийн 3D баримтжуулалт	13
Зураг 11. Оршуулга илэрсэн байдал.....	13
Зураг 12. Хар Байцын агуйн харагдах байдал	13
Зураг 13. B060 дурсгалаас илэрсэн хүний яс	14
Зураг 14. Дурсгал C79a болон Дурсгал C094	14
Зураг 15. Чулуун зэвсгийн олдвор олдож буй газрын гадарга.....	14
Зураг 16. Хайгуулаар илэрсэн чулуун зэвсгүүд.....	15
Зураг 17. БОТБУ тайлангийн нүүр болон ЕҮДүгнэлт	16

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УЦС барих төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, ТЖБОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүс дэх оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөнд 4,739,680,170.0 төгрөгийг төлөвлөсөн болно. Монгол улсын Эрчим хүчний сайдын 2023 оны 10 сарын 17-ны өдрийн А/231 тоот “Тушаал шинэчлэн тогтоох тухай” тушаалаар Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, Түр замын БОТБУ, Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, Төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрд олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөллийн судалгаа зэрэг ажлуудад 4,363,470,424.0 төгрөг, Нүүлгэн шилжүүлэх, нэг удаагийн нөхөн төлбөрт 4,496,174,546.0 төгрөг баталсаны дагуу биелэлтийн тайланг боловсруулав /тушаалыг хавсралтаар тусгав/.

БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” хойшлогдсоны улмаас төслийн талбайд барилга байгууламжийн ажил эхлээгүй тул 2023 оны БОМТ-нд тусгагдсан Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ; Орчны тохижилт, нөхөн сэргээлт; Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө; Хог хаягдлын менежмент; Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт хойшилж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг 2024 оны төлөвлөгөөнд тусгахаар боловсруулаад байна.

2023 онд төлөвлөсөн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Биелэлтийн тайлбар
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” хийгдээгүй учир төлөвлөсөн хугацаанд төслийн талбайд барилга байгууламжийн ажил хойшилсон. Үүнтэй холбогдуулан БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлууд хийгдээгүй байна.
Орчны тохижилт, нөхөн сэргээлт	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр”-тэй холбогдуулан төслийн барилгын ажил эхлээгүй тул БОМТ-нд тусгагдсан орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажил хэрэгжээгүй байна.
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	Бүлэг 1-д тайлагнасан.
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Бүлэг 2-д тайлагнасан.
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” хийгдээгүй учир төлөвлөсөн хугацаанд төслийн талбайд барилга байгууламжийн ажил хойшилсон. Үүнтэй холбогдуулан БОМТ-нд тусгагдсан осол эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө хэрэгжээгүй байна.
Хог хаягдлын менежмент	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр”-тэй холбогдуулан БОМТ-нд тусгагдсан орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажил 2023 онд хэрэгжээгүй байна.
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	БНХАУ-ын ЭКСИМ банктай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” хойшилсонтой холбогдуулан ОХШХ-ийн оронд “Ховд аймгийн Эрдэнбүрэн сумын нутагт баригдах түр зам”-ын дагуух Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийж гүйцэтгүүлсэн. Бүлэг 3-д тайлагнасан.
Удирдлага зохион байгуулалт	Бүлэг 4-д тайлагнасан.
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэцүүлэх хуваар	Бүлэг 5-д тайлагнасан.

1 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

ДД	Болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1.	Улиаст, Цэцэгт, Баяннуур, Эрдэнэбүрэн, Мянгад багийн малчин айл өрхүүд	Эд хөрөнгийн нөхөн олговрыг бүрэн олгох	Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөнд төслийн нөлөөлөлд өртөж буй айл өрхүүдийн эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээг байгуулах, нөхөн төлбөр шилжүүлэх эрхийг аймаг орон нутгийн ЗДТГ-т олгох ажлыг зохион байгуулан ажилласан. Тухайлбал: Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум: * Эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээ байгуулсан – 8 айл өрхөд 93,780,000.0 төгрөг олгогдсон. Увс аймгийн Өмнөговь сум: * Эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээ байгуулсан – 113 айл өрх 517,430,400.0 төгрөг олгогдсон. Баян-Өлгий аймгийн Баяннуур сум: * Эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээ байгуулсан – 140 айл өрхөд 3,251,571,504.0 төгрөг олгогдсон байна. Эд хөрөнгийн нөхөн олговрыг олгох ажлын хүрээнд нийт 278 айл өрхтэй эд хөрөнгийн нөхөн олговор олгох гэрээг байгуулахаас: Нэр давхацсан 3, гадаадын харъяат 2, гэрээ байгуулаагүй 12 айл өрхийн иргэн, гэрээ байгуулж, нөхөн олговроо авсан 261 айл өрх байна.
2.	Шинээр барих Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн ерөнхий төлөвлөгөө болон барилгын зураг төсөл боловсруулах ажил		Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийг нүүлгэн шилжүүлэх, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багт шинэ суурьшлын бүс байгуулах зураг төлсийн ажлын Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг Монголын архитекторуудын эвлэлийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2023.02.10-ны өдөр орж хэлэлцэгдсэн бөгөөд дүгнэлт 2023.04.10-ны өдөр 1-11/23 тоот дүгнэлт гарсан. Улмаар Барилга хот байгуулалтын яамны Сайдын тушаалаар байгуулагдах комиссоор магадлал хийгдэж байгаа бөгөөд 12 сард багтаан ажлыг гүйцэтгэлийг хангуулахаар ажиллаж байна.
3.	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн шинэ суурьшилын бүс, 160 хүүхдийн сургууль, 50 хүүхдийн цэцэрлэгийн ерөнхий төлөвлөгөө болон барилгын зураг төсөл боловсруулах ажил		


1.1 Эд хөрөнгийн нөхөн олговрыг бүрэн олгох

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан айл өрхийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой олгогдож буй нөхөн олговор нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2023 оны зардлын төсөвт Эрчим хүчний сайдын 2023 оны 05 сарын 08-ны өдрийн А/107 тоот тушаалын нэгдүгээр хавсралтад зааснаар 3,795,389,650.0 төгрөг байхаар баталсан.

Эд хөрөнгийн нөхөн олговор болон нэг удаагийн гэрээ байгуулах эрхийг ЭХСайдын 2023 оны 06 сарын 12-ны өдрийн дугаар А/125 тушаалын дагуу Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын Засаг даргын тамгын газар-т шилжүүлсэн.

2021 онд батлагдсан төслийн БОННУ-ний тайлан, 2022 онд батлагдсан Түр замын БОТБУ-ний тайланг үндэслэн:

- ✓ Увс аймгийн Өмнөговь сум: 125 айл өрхөөс 118 айл өрхтэй эд хөрөнгийн гэрээг байгуулсан;
- ✓ Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум: 8 айл өрхтэй эд хөрөнгийн гэрээг байгуулсан;
- ✓ Баян-Өлгий аймгийн Баяннуур сум: 145 айл өрхөөс 135 айл өрхтэй эд хөрөнгийн гэрээг байгуулсан.




Зураг 1. Эрх шилжүүлсэн албан бичиг

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146 дугаар “Нэг удаагийн нөхөн төлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд төслийн нөлөөлөлд өртөж буй айл өрхийн

иргэн бүрд нэг удаагийн нөхөн төлбөрийг олгохоор тусгасан байна. Тус тогтоолын дагуу Засгийн газрын нөөц хөрөнгөөс 2022 онд 1,0 тэрбум төгрөг; 2023 онд 1,0 тэрбум; нийт 2,0 тэрбум төгрөг иргэдэд олгогдсон. Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 246 дугаар “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146 дугаар тогтоол хүчингүй болж, ЭХСайдын 2023 оны 10 сарын 16-ны өдрийн А/228 дугаар тушаалаар түр журам батлагдсанаар 2023 онд 4,496,174,546.0 төгрөг олгогдохоор бэлтгэл ажил хангагдаад байна.

Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөнд төслийн нөлөөлөлд өртөж буй айл өрхүүдийн эд хөрөнгийн нөхөн олговрын гэрээг байгуулах, нөхөн төлбөр шилжүүлэх эрхийг аймаг орон нутгийн Засаг даргын тамгын газарт олгох ажлыг зохион байгуулсан. Тухайлбал 2021 онд батлагдсан төслийн БОННУ-ний тайлан, 2022 онд батлагдсан Түр замын БОТБУ-ний тайланг үндэслэн:

- ✓ Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумын 37 иргэнтэй нэг удаагийн нөхөн олговрын гэрээ байгуулсан.
- ✓ Увс аймгийн Өмнөговь сумын 468 иргэнтэй нэг удаагийн нөхөн олговрын гэрээ байгуулсан.
- ✓ Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 351 иргэнтэй нэг удаагийн нөхөн олговрын гэрээ байгуулсан.




Зураг 2. Нэг удаагийн нөхөн төлбөр аймаг руу шилжүүлэхийг хүссэн баримт


Төслийн барилга байгууламж болон нуур үүсэх талбайн нөлөөлөлд өртөж буй 278 айл өрхийн 261 айл өрхөд эд хөрөнгийн нөхөн олговор бүрэн олгогдсон, 278 өрхийн 1278 иргэний 400 иргэнд нэг удаагийн нөхөх олговрын 4,496,174,546 төгрөгийг олгоод байна.

1.2 Улиаст багийн төвийн зураг төслийн ажил


Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн зураг төсөл боловсруулах ажлын гэрээг “Аркуос” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ /Дугаар №202205054/-г байгуулсан. Увс аймгийн ЗДТГаараас баталсан ажлын даалгаврын дагуу ажиллаж 2022 онд 70%-ийн гүйцэтгэлтэйгээр хүлээлгэж өгсөн.



Зураг 3. Улиаст багийн төвийн ерөнхий төлөвлөгөө



Зураг 4. Цэцэрлэгийн зохион байгуулалт, Захираганы байрны зохион байгуулалт



Зураг 5. Сургуулийн гадаад байгуулалт, Үйлчилгээний төвийн зохион байгуулалт




Зураг 6. Харагдах байдал

“Аркосис” ХХК-ийн зүгээс гэрээг дахин сунгах хүсэлтийг Эрчим хүчний яам хүлээн авч 2022 оны 12 сарын 28-нд ЭХЯ/202205054-ГНӨ-02 дугаар Гэрээний нэмэлт өөрчлөлтөөр хугацааг хуанлийн 70 хоног буюу 2023 оны 02 сарын 21-ны өдөр хүртэл сунгасан байна. Улиаст багийн төвийн зураг төслийн ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан бөгөөд 2023 оны 06 сарын 27-ны өдрийн өдрийн Барилга хот байгуулалтын сайдын 158 дугаар “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу 12 гишүүн бүхий ажлын хэсэг томилогдон ерөнхий төлөвлөгөөний магадлал хийлгүүлэх ажил 100% хийгдэж экспертүүдийн дүгнэлт гарсан. Одоогийн байдлаар ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан барилгын зураг төсөвт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Тус ажлыг 2024 онд хүлээж авахаар төлөвлөж байна.


						Экспертийн дүгнэлтүүд
2	2023-07-03 Дэлгэрэнгүй	СО-22/11	Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө	Увс аймаг, Өмнөговь сум	Барилга, хот байгуулалтын яам	<div style="text-align: center;"> <p>Экспертийн дүгнэлт бүрэн гарч дууссан</p> <p>100%</p> <p>Экспертийн дүгнэлтүүд</p> <p>★★★★★ -</p> <p>Онц</p> </div>

1.3 Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл /160 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл, 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын иж бүрэн зураг төсөл/ боловсруулах ажлын гэрээг “Аркосис” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ /Дугаар №202205055/-г байгуулсан. Баян-Өлгий аймгийн ЗДТГазраас баталсан ажлын даалгаврын дагуу ажиллаж 2022 онд 70%-ийн гүйцэтгэлтэйгээр хүлээлгэж өгсөн.



Зураг 7. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн ерөнхий төлөвлөгөө



Зураг 8. Баяннуур сумын 160 хүүхдийн сургуулийн харагдах байдал

“Аркосис” ХХК-ийн зүгээс гэрээг дахин сунгах хүсэлтийг Эрчим хүчний яам хүлээн авч 2022 оны 12 сарын 28-нд ЭХЯ/202205054-ГНӨ-02 дугаар Гэрээний нэмэлт өөрчлөлтөөр хугацааг хуанлийн 70 хоног буюу 2023 оны 02 сарын 21-ны өдөр хүртэл сунгасан байна. Улиаст багийн төвийн зураг төслийн ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан бөгөөд 2023 оны 06 сарын 27-ны өдрийн өдрийн Барилга хот байгуулалтын сайдын 158 дугаар “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу 12 гишүүн бүхий ажлын хэсэг томилогдон ерөнхий төлөвлөгөөний магадлал хийлгүүлэх ажил 100% хийгдэж экспертүүдийн дүгнэлт гарсан. Одоогийн байдлаар ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан барилгын зураг төсөвт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Тус ажлыг 2024 онд хүлээж авахаар төлөвлөж байна.

3	2023-07-03 Дэлгэрэнгүй	СО-22/12	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө	Баян-Өлгий аймаг, Баяннуур сум	Барилга, хот байгуулалтын яам	<p>✓ Экспертийн дүгнэлт бүрэн гарч дууссан</p> <p>100%</p> <p>Экспертийн дүгнэлтүүд</p> <p>★★★ - Дунд</p>
---	---------------------------	----------	--	--------------------------------	-------------------------------	---

2 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

дд	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1.	Соёлын биет бус өвийн тандалт судалгаа	Төслийн хүрээнд тусгай хэрэгцээнд авсан 28000 га газар нутгийн хэмжээнд хайгуул судалгаа хийх	2023 оны БОМТ төлөвлөгөөнд тусгагдсан соёлын биет бус өвийн судалгаа, хайгуулын ажлыг хэрэгжүүлэх зардлын төсвийг ЭХСайдын 2023.05.08 өдрийн А/107 тоот албан тоотоор батлуулсан. Судалгааны ажлын даалгавар 2023.08.15 өдрийн ЭХЯ-ны в/2682 дугаар албан тоотоор батлагдан ТХН-д хүргэгдсэний дагуу 2023 оны 11 сард тендер зохион байгуулж, ажлын гэрээг байгуулан 2023 оны 12 сард тайланг хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна.
2.	Археологийн олдворууд	Барилгын талбайд хамаарагдах соёлын биет өвийг малтах, нүүлгэн шилжүүлэх	Төслийн барилгажих талбайд байрлаж буй "Соёлын биет өв"-ийн 20 олдворыг авран хамгаалах ажлыг Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээр гүйцэтгүүлэхээр АҮГ-2023/76 дугаар бүхий "Археологийн малтлага судалгааны ажлын гэрээ"-г 2023.04.30-ны байгуулсан. Түүний дагуу 2023.05.31 өдрөөс 2023.07.09 өдрийн хооронд Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сумын нутагт дахь төслийн барилгажих талбарт хамаарах археологийн 23 дурсгал (судалгаанд авто зам дагуу өртөх 3 дурсгал нэмж бүртгэгдсэн байна)-ыг авран хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгүүлэн ажлын тайланг хүлээн авсан.

2.1 Соёлын биет бус өв буюу Угсаатан зүйн авран хамгаалах тандалт судалгаа

2023 оны БОМТ төлөвлөгөөнд тусгагдсан соёлын биет бус өвийн судалгаа, хайгуулын ажлыг хэрэгжүүлэх зардлын төсвийг ЭХСайдын 2023.05.08 өдрийн А/107 тоот албан тоотоор батлуулсан. Судалгааны ажлын даалгавар 2023.08.15 өдрийн ЭХЯ-ны в/2682 дугаар албан тоотоор батлагдан ТХН-д хүргэгдсэний дагуу 2023 оны 11 сард тендер зохион байгуулж, ажлын гэрээг байгуулан 2023 оны 12 сард тайланг хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна.

Одоогийн байдлаар тус судалгааг гүйцэтгэхээр ШУА-ийн Түүх угсаатан зүйн хүрээлэн, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Цахим суврага соёлын өвийн эрэл хайгуулчид НҮТББ газрууд шалгараад байна.

2.2 Соёлын биет өвийн авран хамгаалах малтлага судалгаа

Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах” тухай хуулийн хүрээнд ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй байгуулсан АҮГ-2023/76 дугаар бүхий “Археологийн малтлага судалгааны ажлын гэрээ”-ний дагуу ажлыг гүйцэтгүүлж, тайланг 2023 оны 08 сарын 28-нд хүлээн авсан.

ШУА-ийн Археологийн хүрээлэн нь гэрээний дагуу 2023 оны 05 дугаар сарын 31-ээс 07 дугаар сарын 09-ийг дуустал 40 хоногийн хугацаанд Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сумын нутаг дахь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн барилга, бүтээн байгуулалтын талбайд орших археологийн 23 дурсгалын малтлага судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэв. Үүнд, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт хүрэл зэвсгийн үед холбогдох “Хиргисүүр ба буган хөшөөний соёл”-ын оршуулгын дурсгал 1 (С078), мөн хүрэл зэвсгийн үеийн булш 12 (С079, С080, С088-С096, С098), Ховд аймгийн Мянгад сумын нутагт хүрэл зэвсгийн үеийн булш 5 (В059, В060, В074, В082, В083), тахилын байгууламж 2 (В076, В076а), түрэгийн үед холбогдох тахилын байгууламж 1 (В075), агуй 1 (В220), Увс аймгийн Өмнөговь сумын нутагт нүүрс шатаах зуух 1 (А434) тус тус багтаж байна. Увс аймгийн Өмнөговь сумын нутагт хайгуулаар илэрсэн барилга, бүтээн байгуулалтын талбайд орсон нүүрс шатаах зуух буюу А434 дугаартай дурсгал бүтээн байгуулалтын автозамын трасст өртсөн тул судалгаанд хамрагдаагүй болно. Судалгаанд замын далан болон автозамд өртөж буй Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт орших С078, Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших В076а, В082 дугаартай дурсгалууд нэмж хамрагдав.

Археологийн малтлага судалгааны явцад С078 дугаартай оршуулгын чулуун хайрцаг, тахилын байгууламжтай хиргисүүрийн гадна чулуун хүрээний орчмоос Еврази төрлийн буган хөшөө шинээр илрүүлэв. Мөн С079 дугаартай битүү чулуун овоолготой дугуй хэлбэртэй хүрлийн үеийн булшнаас оршуулгын хос чулуун хайрцагт хүнээ оршоосон хос оршуулга илэрсэн нь Алтайн бүс нутгийн хэмжээнд анхны тохиолдол болж байна. Хос оршуулгын нэгд 30-35 насны холимог төрхийн эрэгтэй хүний яс илэрсэн бол нөгөө оршуулгаас хадгалалт муу, хүйс тодорхойлох боломжгүй 18-22 орчим насны хүний яс тус тус илрэв. Малтлага судалгаагаар С079, С080, С089, С090, С091, С092, С094, С095, В059, В060, В074, В082 дугаартай булшнаас хүний яс, С079, С080, С095, В060, В075, В082, В220 дугаартай дурсгалаас мал, амьтны яс бүрэн, бүрэн бус байдлаар илэрч олдсон нь палеоантропологи, зооархеологийн судалгааны Алтайн бүс нутгийн баялаг хэрэглэгдэхүүн болж дурсгалын он цагийг тогтоох, эртний хүн амын угсаа гарал, тархалт, шилжилт хөдөлгөөн зэрэг олон чухал мэдээллийг тодруулахад эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой юм. Цаашид хүн, мал, амьтны ясны дээжид лабораторийн нарийвчилсан он цаг тогтоох судалгаа хийлгэхээр төлөвлөж байна.


Мөн С079 дурсгалаас хүрэл чимэглэл, ваар савны хагархай, С080 дурсгалаас нүхэлсэн сувс чимэглэл, В083 дурсгалаас ваар савны хагархай 10 ш, В226 дурсгалаас ваар савны хагархай 4 ш тус тус илэрч олдсон нь соёлын хамаарлыг тодорхойлох чухал хэрэглэгдэхүүн

болж байна. Судалгаанд хамрагдсан булш оршуулгын дурсгалуудыг эрт цаг тонож сүйтгэсэн хэдий ч малтлагын үр дүнд дурсгалын гадаад, дотоод бүтэц зохион байгуулалтыг орчин үеийн дэвшилтэд технологи, багаж төхөөрөмжийн тусламжтай тодорхойлон баримтжуулав. B226 дурсгал буюу Хар Байцын агуйн малтлагаас ваар савны хагархай, мал, амьтны ясны үлдэгдэл цөөнгүй илэрсэн нь хүрэл зэвсгийн үе буюу түүнээс хожуу үеүдэд хүмүүс түр хугацаагаар, ан гөрөө хийх зорилгоор амьдарч байсныг гэрчилж байна.

Малтлага судалгааны зэрэгцээ Шижигтийн хавцлын адаг орчим, Ховд голын зүүн дэнж орчмоос чулуун зэвсгийн 40 орчим олдвор, чулуун залтас, үлдцийг сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулж, харьцуулсан судалгаагаар доод палеолитын төгсгөл үе (100 мянган жил)-ээс дээд палеолитын эхэн үе (40 мянган жил) хүртэлх хугацаанд хамаарахыг тодорхойлов. Чулуун зэвсгийн дурсгалт газрууд нь эртний хүмүүс амьдарч байсан ил суурины төрөлд хамаарч байна.

Археологийн хүрээлэнгийн малтан шинжилсэн археологийн дурсгалууд нь он цагийн хувьд одоогоос 3500-3000 жил буюу хүрэл зэвсгийн үе, мөн VI-VIII зууны түрэгийн үед холбогдох бөгөөд урьд өмнө археологийн судалгаа харьцангуй бага явагдсан Алтайн бүс нутагт эрт цагаас хүн тасралтгүй оршин амьдарч байсан, оршуулгын өвөрмөц зан үйл, олон соёлын үйл явц бүрэлдэн тогтсон болохыг харуулах судалгаа болж чадсанаараа эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой юм гэж тодорхойлсон байна. Малтлагын олдворуудыг дараах байдлаар баримтжуулсан байна /гэрээг хавсралтаар тусгав/. Үүнд:

Булш, хиргисүүр:



Зураг 9. Булшны өндөршилтийг харуулсан зураг



Зураг 10. Чулуун хайрцгийн 3D баримтжуулалт



Зураг 11. Оршуулга илэрсэн байдал

Агуй:




Зураг 12. Хар Байцын агуйн харагдах байдал

Палеоантропологи:



Зураг 13. B060 дурсгалаас илэрсэн хүний яс



Зураг 14. Дурсгал С79а болон Дурсгал С094

Чулуун зэвсгийн үеийн зэвсэг:




Зураг 15. Чулуун зэвсгийн олдвор олдож буй газрын гадарга



Зураг 16. Хайгуулаар илэрсэн чулуун зэвсгүүд

3 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР /ТҮР ЗАМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ/

Тухайн жилийн БОМТ-нд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тусгагдсан байсан боловч БНХАУ-тай байгуулах тусгайлсан зээлийн хэлэлцээр хойшилсонтой холбогдуулан нэн түрүүнд хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн ОХШХ-ийн оронд хэрэгжүүлсэн. Тухайлбал: Ховд аймгийн Засаг даргын 2023 оны 07 сарын 06-ны өдөр баталсан “Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станц барих” төсөл хэрэгжих “Ховд аймгийн Эрдэнбүрэн сумын нутагт баригдах түр зам”-ын дагуух Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх ажлын даалгаврын дагуу бид сонгон шалгаруулалт зарласан. Тус Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх ажлыг “Текол” ХХК-аар гүйцэтгүүлж, Ховд аймгийн Байгаль орчны газар хүлээн авч хянан Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гарган, таван жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан байна /гэрээг хавсралтаар тусгав/.



Зураг 17. БОТБУ тайлангийн нүүр болон ЕҮДүгнэлт

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

дд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлбар
1.	Түүх соёл, археологийн олдвор, булш, бунхныг авран хамгаалах, малтлага судалгааны ажлыг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах	Төслийн барилгажих талбайд байрлаж буй "Соёлын биет өв"-ийн 20 олдворыг авран хамгаалах ажлыг Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээр гүйцэтгүүлэхээр АҮГ-2023/76 дугаар бүхий "Археологийн малтлага судалгааны ажлын гэрээ"-г 2023.04.30-ны байгуулсан. Түүний дагуу 2023.05.31 өдрөөс 2023.07.09 өдрийн хооронд Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сумын нутагт дахь төслийн барилгажих талбарт хамаарах археологийн 23 дурсгал (судалгаанд авто зам дагуу өртөх 3 дурсгал нэмж бүртгэгдсэн байна)-ыг авран хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгүүлэн ажлын тайланг хүлээн авсан.
2.	Тухайн жилийн "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-г өмнөх оны 12-р сард багтаан БОАЖЯ-аар батлуулж, 3 аймгаар дүгнүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд бэлтгэл хангах	Төслийн Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөг батлуулахтай холбоотой дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: ✓2023 оны БОМТ, хийгдэх арга хэмжээнүүдтэй уялдсан зардлын төсвийг батлуулсан. ✓Ховд аймгийн айл өрхийн эд хөрөнгийн нөхөн олговрын санхүүжилтийг 2023 онд 100% олгохоор шийдвэрлэсэн. ✓2023 оны 04 дүгээр сарын 14 өдрийн ТУХ-ны хуралд 2023 оны БОМТ-г танилцуулан, гишүүдийн санал зөвлөмжийг тусган БОАЖЯ-аар батлуулахаар дэмжигдсэн. ✓2023 оны БОМТ-г ТУХ-ны зөвлөмжийн хамт 2023 оны 04 сарын 26-ны өдөр БОАЖЯ-ны сайтад цахимаар илгээсэн. ✓2023 оны БОМТ-г 05 сарын 16-ны өдөр БОАЖЯ батлуулсан. ✓ЭХС-ын багцад тусгагдсан төсвийн хүрээнд БОМТ-ыг хэрэгжүүлэх зардлын төсвийг ЭХС-ын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дугаар А/107 тоот тушаалаар батлуулсан болно.
3.	Төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрт олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөний судалгаа хийх ажлын зардал	Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрд олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөллийн судалгааг хийх АҮГ-2023/82 тоот гэрээний дагуу айл өрхийн иргэн бүрт олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөний судалгааг бусдаар гүйцэтгүүлэн ажлын тайланг 2023 оны 08 сард хүлээн авсан.
4.	Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумдын ИНХ төлөөлөгчид болон нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, малчид	Төслийн бэлтгэл ажлын явцад хэрэгжүүлэх зарим ажлын төлөвлөгөөг хойшлуулан төслийн нуур үүсэх талбайн нөлөөлөлд өртөж буй Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын айл өрхийн иргэдийн төлөөллийг Тайшир, Дөргөний УЦС үзүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллав.

4.1 Соёлын биет өвийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг зохион байгуулах

Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах” тухай хуулийн хүрээнд ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй байгуулсан АҮГ-2023/76 дугаар бүхий “Археологийн малтлага судалгааны ажлын гэрээ”-ний дагуу ажлыг гүйцэтгүүлж, тайланг 2023 оны 08 сарын 28-нд хүлээн авсан. Дэлгэрэнгүйг Бүлэг 6.2-т тусгав.

4.2 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэл ажил

Төслийн Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөг батлуулахтай холбоотой “Төслийн удирдах хороо”-ны хурлаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг танилцуулсан. Тухайлбал:

1. Тухайн жилийн БОМТ, хийгдэх арга хэмжээнүүдтэй уялдсан зардлын төсвийг Эрчим хүчний сайдаар батлуулсан.
2. Ховд аймгийн айл өрхийн эд хөрөнгийн нөхөн олговрын санхүүжилтийг 2023 онд 100% олгохоор шийдвэрлэсэн.
3. Тухайн жилийн БОМТ-г танилцуулан, гишүүдийн санал зөвлөмжийг тусган БОАЖЯ-аар батлуулахаар дэмжигдсэн.
4. Тухайн жилийн БОМТ-г ТУХ-ны зөвлөмжийн хамт 2023 оны 04 сарын 26-ны өдөр БОАЖЯ-ны сайтад цахимаар илгээсэн.
5. Тухайн жилийн БОМТ-г 05 сарын 16-ны өдөр БОАЖЯ-аар батлуулсан.

Эрчим хүчний сайдын багцад тусгагдсан төсвийн хүрээнд БОМТ-ыг хэрэгжүүлэх зардлын төсвийг ЭХС-ын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дугаар А/107 тоот тушаалыг 2023 оны 10 сарын 17-ны өдрийн А/231 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан. Тус төсвийн хүрээнд биелэлтийн тайланг боловсруулсан болно.

4.3 Төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрт олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөний судалгаа хийх

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн хэрэгцээнд зориулан авсан газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртөх айл өрхийн иргэн бүрд олгох нэг удаагийн нөхөх төлбөрийн хэмжээг тооцоолох нь нөлөөлөлд өртөх айл өрх, иргэдэд эдийн засгийн хувьд чухал үүрэгтэй. Иймд төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрд олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөллийн судалгааг “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-тай хийсэн АҮГ-2023/82 тоот гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг 2023 оны 08 сард хүлээн авсан. Тус тайлангийн дүгнэлтэд дурдсанаар:

Олон улсын туршлагаас харахад бүтээн байгуулалтын төсөлтэй холбоотой төслийн хэрэгцээнд зориулсан газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийг биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт гэсэн хэлбэрээр зохион байгуулж байна. Мөн эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийг эдийн засгийн хувьд хохирол, алдагдалд хүрэх эрсдэл, цаашлаад амьжиргааны түвшинд сөрөг өөрчлөлт гарч болзошгүй байдалд хүргэхгүйн тулд нөлөөлөлд өртөх айл өрхийн амьжиргаа, орлогыг хэвийн түвшинд байлгахад гол анхаарлаа хандуулж байна.

Захиалагч тал, орон нутгийн төрийн байгууллага болон төслийн нэгжээс ирсэн мэдээлэлд үндэслэн төслийн нөлөөлөлд өртөх айл өрхийн амьжиргаа, орлогын тооцооллыг 2 түвшинд хийж гүйцэтгэсэн. Тухайлбал:

- ✓ Төслийн нөлөөлөлд өртөх айл өрхийн талаарх мэдээллийг ашиглан мал аж ахуй болон хадлангаас олох орлогын тооцооллыг хийсэн.
- ✓ Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны сүүлийн 5 жилийн мэдээллийг боловсруулж, үр дүнг төслийн нөлөөлөлд өртөх айл өрхөд тараах байдлаар өрхийн амьжиргаа, нийт орлогын тооцоо, цаашлаад гол хүлээгдэж байсан үр дүн болох нөхөн төлбөрийн хэмжээг тооцсон.

Нөлөөлөлд өртөх малтай айл өрхийг малын төрлөөр бүтцийг авахад ихэнх хувийг бог мал, тэр дундаа ямаан сүрэг бүрдүүлж байна. Энэ нь тухайн өрхийн ноос, ноолуураас олох орлого нь мал аж ахуйгаас олох орлогын гол бүрдэл хэсэг болохыг харуулж байна.

Төслийн нөлөөлөлд өртөх айл өрхийн мал аж ахуйгаас олох орлогын ихэнх хувийг ноос, ноолуур болон мах, арьс ширнээс олох орлого бүрдүүлж байна.

Нөхөн олговрын хэмжээг тооцооллын онцлогоос хамааран хувилбарт байдлаар тооцсон. Өөрөөр хэлбэл, сүүлийн 5 жилийн дундаж үнэлгээгээр төслийн нөлөөлөлд өртөх айл өрхийн гишүүн бүрд 3 жилийн хугацаанд нийт 14,896.6 мянган төгрөгийн нөхөн олговор олгохоор байна.

Төслийн нөлөөлөлд өртөх нэг өрхийн жилийн дундаж нийт орлого (мал аж ахуйн үндсэн бүтээгдэхүүн, хадлангаас олох орлого + бусад орлого)-д үндэслэн нөхөн төлбөрийн хэмжээг тооцсон учир эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой учирч болох эрсдэлийг даван туулах боломжтой гэж дүгнэсэн байна /гэрээг хавсралтаар тусгав/.

4.4 Эрдэнэбүрэн, Мянгад, Өмнөговь, Баяннуур сумдын ИНХ төлөөлөгчид болон нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, малчид

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх үүднээс Зээлийн тусгайлсан хэлэлцээрийн явцад хөрөнгө оруулагч БНХАУ-ын Эксим банкны өмнө Монгол Улсын талаас хүлээсэн үүргийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссаны дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах, үнэн бодитой мэдээлэл хүргэх зорилгоор төслийн нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн, Өмнөговь сумын Улиаст баг, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Ховд аймгийн Мянгад сумын ард иргэдийн төлөөлөл нийт 45 хүнийг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Тайширын УЦС, Дөргөний УЦС-ын үйл ажиллагаа, ач холбогдол, үр нөлөө, нөхцөл байдлыг газар дээр нь үзүүлж таниулах, танилцах аяллыг инженер техникийн ажилчдын бүрэн бүрэлдхүүнтэйгээр зохион байгуулж соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажилласан.





Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс аяллын багийн төлөөллүүдэд холбогдох хариуцлыг өгч эрчим хүчний хараат байдлаас ангижрах, баруун бүсийн аймгийг эрчим хүчээр бүрэн хангах, төвийн эрчим хүчний системд нийлүүлэх боломж бүрдэж үнэ тогтворжих зэрэг олон чухал ач холбогдолтой болох талаар, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох ажлыг хуулийн хүрээнд Байгаль орчны үүсч болох эрсдлээс сэргийлж ажиллах талаар сурталчлан таниулж ажилласан.

Мөн “Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн танилцуулга, Тайшир, Дөргөний усан цахилгаан станцыг үзэж танилцсан сэтгэгдлээр сурталчилгааны соён гэгээрүүлэх телевизийн нэвтрүүлгийг “Монголын баримтат кино, гэрэл зураг, дуу авианы үндэсний нийгэмлэг”-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлээд байна. Богино хэмжээний баримтат нэвтрүүлгийг хүлээн авсан бөгөөд гэрээг хавсралтаар тусгав.

5 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

дд	Арга хэмжээ	Тайлбар
1.	БОМТ-ний биелэлтийг тайлагнах цахимд байршуулах	БНХАУ-ын ЭКСИМ банкттай байгуулах “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” 2023 оны 07 сард хийгдэн, барилга байгууламжийн бүтээн байгуулалт эхлэх байсан боловч 2023 оны 10 сард зээлийн хэлэлцээр хийгдсэн. Тус шалтгааны улмаас төслийн талбайд барилга байгууламжийн ажил 2024 оноос эхлэхээр төлөвлөгдөөд байна. Боомтын барилга байгууламжийн ажил хараахан эхлээгүй байгаа тул БОМТ-д тусгагдсан зарим арга хэмжээний төлөвлөгөөг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж БОАЖЯ-аар батлуулахаар ажиллаж байна.
2.	Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн Байгаль орчны газраар биелэлтийн тайланг дүгнүүлэх	
3.	БОАЖЯ-аар Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах	

ХАВСРАЛТ



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/231

Улаанбаатар хот

Тушаал шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.3, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 146 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 246 дугаар тогтоол, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн Төслийн удирдах хорооны 2023 оны 2023/05 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг нэгдүгээр хавсралтаар, нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрд олгох нэг удаагийн нөхөн төлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Эрчим хүчний сайдын 2023 оны урсгал зардлын төсвөөс “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” эдийн засгийн ангиллаас нэгдүгээр хавсралтаар батлагдсан төсвийг, “Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал” эдийн засгийн ангиллаас хоёрдугаар хавсралтаар батлагдсан төсвийг тус тус санхүүжүүлсүгэй.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Н.Тавинбэх)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан, Эрчим хүчний сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/107 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600000562

10
231

Эрчим хүчний сайдын 2023 оны
10 дүгээр сарын 17-ны өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/төгрөгөөр/

№	Зардлын үзүүлэлт	Эхлэх	Дуусах	2023 оны зардлын төсөв
1	Нүүлгэн шилжүүлэх, Эд хөрөнгийн нөхөн олговрын төлөвлөгөөний зардал	2022	2023	3,990,572,424
1.1	Баян-Өлгий аймаг	2023	2023	3,251,571,504
1.2	Увс аймаг	2023	2023	517,430,400
1.3	Ховд аймаг	2023	2023	93,780,000
1.4	б) Шинээр барих Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвийн зураг төсөл боловсруулах ажил	2022	2023	70,883,010
1.5	в) Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн шинж суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл / 160 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл, 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын иж бүрэн зураг төсөл боловсруулах ажил	2022	2023	56,907,510
2	Түүх, соёлын өвийг авран хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	2022	2023	281,578,000
2.1	Археологийн түүх соёлын дурсгалт зүйлсийн авран хамгаалах арга хэмжээ	2023	2023	221,578,000
2.2	Соёлын биет бус өвийн судалгаа, хайлуулын ажил	2023	2023	60,000,000
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал			91,320,000
3.1	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2023	2023	28,350,000
3.2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	2023	2023	42,970,000
3.3	Төслийн нөлөөлөлд хамаарах айл өрхийн иргэн бүрт олгох нөхөн төлбөрийн үндэслэл, үр нөлөөний судалгаа хийх ажлын зардал	2023	2023	20,000,000
Нийт дүн				4,363,470,424

Эрчим хүчний сайдын 2023 оны
10 дүгээр сарын 17-ны өдрийн
А дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1231



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН
НӨЛӨӨЛД ХАМААРАХ АЙЛ ӨРХИЙН ИРГЭН БҮРД ОЛГОХ НЭГ УДААГИЙН
НӨХӨН ТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/төгрөгөөр/

№	Зардлын үзүүлэлт	Эхлэх	Дуусах	2023 оны зардлын төсөв
1	Нүүлгэн шилжүүлэх, Нэг удаагийн нөхөн төлбөр	2022	2024	4,496,174,546
1.1	Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 135 иргэн	2023	2023	1,461,720,000
1.2	Увс аймгийн Өмнөговь сумын 198 иргэн	2023	2023	2,475,014,546
1.3	Ховд аймаг Эрдэнэбүрэн, Мянгад сумын 37 иргэн	2023	2023	559,440,000



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Газрын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2023 оны зардлын төсвийн 1.1-ийн а) хэсэгт туссан нийт 3,795,389,650 төгрөгөөс Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын айл өрхтэй эд хөрөнгийн нөхөн олговор олгох 3,184,179,250 төгрөгийн нүүлгэн шилжүүлэх гэрээ байгуулах, санхүүжилт олгох эрхийг Баян-Өлгий аймгийн Засаг дарга /А.Камелият/, Увс аймгийн Өмнөговь сумын айл өрхтэй эд хөрөнгийн нөхөн олговор олгох 517,430,400 төгрөгийн нүүлгэн шилжүүлэх гэрээ байгуулах, санхүүжилт олгох эрхийг Увс аймгийн Засаг дарга /Ч.Чимид/, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумын айл өрхтэй эд хөрөнгийн нөхөн олговор олгох 93,780,000 төгрөгийн нүүлгэн шилжүүлэх гэрээ байгуулах санхүүжилт олгох эрхийг Ховд аймгийн Засаг дарга /Э.Болормаа/ нарт тус тус шилжүүлсүгэй.

2. Эд хөрөнгийн нөхөн олговрыг холбогдох баримт бичгийн иж бүрдлийг хангасны үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд орсон нэрсийн жагсаалтын дагуу олгох, нүүлгэн шилжүүлэх ажлын гүйцэтгэл, санхүүжилт, үр дүнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хяналт тавьж, тус яаманд тухай бүр танилцуулж ажиллахыг санхүүжилт олгох эрх шилжсэн аймгуудын Засаг дарга нарт болон Төсөл хэрэгжүүлэх нэгж /Ч.Саранжав/-д даалгасугай.

3. Нөлөөлөлд өртсөн айл өрхөд олгох эд хөрөнгийн нөхөн олговрын санхүүжилтийн 3,795,389,650 төгрөгийг Эрчим хүчний сайдын 2023 оны урсгал зардлын “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” зардлаас тооцон гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /З.Мөнх-Оргил/-д зөвшөөрч, санхүүжилт олгох эрх шилжсэн аймгуудын Засаг дарга нарт шилжүүлэхийг үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600000278



НЭХЭМЖЛЭХ

ДДТД: 000009067043000231017000001661177
 Нэхэмжлэгч:
 ТТД: 9067043
 НЭР: Ховд аймгийн засаг даргын тамгын газар
 Хаяг: Монгол, Ховд, Жаргалант, , ЗДТГ-н байранд, өөрийн
 Утас: undefined
 Э-Шуудан: enkhmandal95@yahoo.com
 Банкны нэр: Төрийн сан
 Банкны дансны дугаар: 100160051410

Хариуцагч:
 ТТД: 5638089
 Нэр: Эрчимхүчний яам
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, , Засгийн
 газрын 14 байр
 Утас:
 Гэрээний №:
 Огноо: 2023-10-17
 Төлбөр хийх хугацаа(Хоног):

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Иргэдийн нөхөн олговор		ш	37	15,120,000	559,440,000



Бараа, ажил үйлчилгээний үнэ:	559,440,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар:	0
Нийслэл хотын албан татвар:	0
Нийт дүн:	559,440,000

Мөнгөн дүн:

(үсгээр)

.....болно

(Тамга)

Захирал:...../...../

Нягтлан бодогч:...../...../

НЭХЭМЖЛЭХ

ДДТД: 000009063781000231026000001062886

Нэхэмжлэгч:

ТТД: 9063781

НЭР: УВС АЙМГИЙН ЗАСАГТ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хаяг: Монгол, , , , Холбооны дэргэд, 0

Утас:

Э-Шуудан: uyanga.m@uvs.gov.mn

Банкны нэр: Төрийн сан

Банкны дансны дугаар: 100150051408

Хариуцагч:

ТТД: 9922431

НЭР: ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСӨЛХаяг: Монгол, Улаанбаатар, Баянзүрх, 26-р хороо,
Хүннүгийн гудамж, Их Монгол төв, 5 давхар, 504
тоот

Утас: 77551516

Гэрээний №: 4

Огноо: 2023-10-26

Төлбөр хийх хугацаа(Хоног): 7

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	198 иргэн нөхөн олговрын төлбөр		ш	1	2,475,014,546.00	2,475,014,546.00
Бараа, ажил үйлчилгээний үнэ:						2,475,014,546.00
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						0.00
Нийслэл хотын албан татвар:						0.00
Нийт дүн:						2,475,014,546.00



Мөнгөн дүн:

(үсгээр)

болно

(Тамга)

Захирал:...../...../

Нягтлан бодогч:...../...../



EBARIMT.MN

НЭХЭМЖЛЭХ

ДДТД: 000009006311000231108000001856625
 Нэхэмжлэгч:
 ТТД: 9006311
 НЭР: Баян-Өлгий аймгийн засаг даргын тамгын газар
 Хаяг: Монгол, , , , сумын төв, еерийн байранд
 Утас: undefined
 Э-Шуудан: bekbolat_2013@yahoo.com
 Банкны нэр: Төрийн сан
 Банкны дансны дугаар: 100020051407

Хариуцагч:
 ТТД: 5638089
 Нэр: Эрчимхүчний яам
 Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, , Засгийн газрын 14 байр
 Утас:
 Гэрээний №:
 Огноо: 2023-11-02
 Төлбөр хийх хугацаа(Хоног):

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Баяннуур сум усан цахилгаан станц нөхөн оловор		ш	1	1,461,720,000	1,461,720,000



Бараа, ажил үйлчилгээний үнэ:	1,461,720,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар:	0
Нийслэл хотын албан татвар:	0
Нийт дүн:	1,461,720,000

Мөнгөн дүн:
 (үсгээр)
болно

(Тамга) Захирал:...../...../
 Нягтлан бодогч:...../...../

БАТЛАВ:
ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ



БАТЛАВ:
ШУА-ИЙН АРХЕОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР



АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖЛЫН ГЭРЭЭ

2023 оны 04 дүгээр сарын ...
-ны өдөр

Дугаар № АҮТ-2023/76 Улаанбаатар хот

Нэг талаас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж, түүнийг төлөөлж Төслийн зохицуулагч Ч.Саранжав (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ШУА-ийн Археологийн хүрээлэн, түүнийг төлөөлж захирал, доктор (Ph.D), дэд профессор Г.Эрэгзэн (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭ (цаашид “гэрээ” гэх)-г байгуулав.

1. Захиалагч нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан археологийн малтлага судалгааны ажлыг “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумдын нутагт байрлах барилга, бүтээн байгуулалтын талбайд илэрсэн 20 дурсгал дээр (цаашид “ажил” гэх) гүйцэтгэхийг Гүйцэтгэгчид даалгаж, түүнтэй холбогдон гарах хөлсийг төлөх ба Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд холбогдох хууль, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэхтэй холбогдсон харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой болгон зохицуулна.
2. Гүйцэтгэгч нь Захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Ажлын нийт хөлс нь 221,578,000 (хоёр хорин нэгэн сая таван зуун далан найман мянга) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Энэ нь Гүйцэтгэгч энэ гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд шаардлагатай (холбогдох татвар, хураамж, бусад) бүх зардлууд багтсан эцсийн үнэ болно. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:


Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Хавсралт:
Хавсралт №1 Ажлын даалгавар
Хавсралт №2 Ажил гүйцэтгэх хуваарь
Хавсралт №3 Багийн бүрэлдэхүүний мэдээлэл
Хавсралт №4 Ажлын зардлын задаргаа
Хавсралт №5 Төлбөр гүйцэтгэх хуваарь

Гэрээ нь дор дурдсан үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.


5. Захиалагч болон Гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Гэрээнд тусгайлан заагаагүй бол Ажил гүйцэтгэхэд гарах шаардлагатай бүх зардал (тээвэр, холбоо, материал хүргэлт, хэвлэлт гэх мэт)-уудыг Гүйцэтгэгч бие даан, бүрэн хариуцна. Энэ гэрээнд заасан ажлыг гүйцэтгэсэнтэй холбогдуулан малтлага судалгааны ажлын дүнд цаашид нэмэлт ажил хийгдэх шаардлагатай болсон

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТӨСЛИЙН НЭГЖИЙН ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР Ж.ЛУВСАНДАНДАР




ТӨСЛИЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН
АЖИЛТАН Б. ОТГОН



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16-р
хороо, Их Монгол гудамж, Их Монгол Төв,
5 давхар, 504 тоот
Утас: 77551516, 99055246

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДОКТОР (Ph.D) Н. ЭРДЭНЭ-ОЧИР



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайван өргөн чөлөө гудамж,
ШУА-ийн Нэгдсэн I байр
[Утас: 452894, 91069595; факс: 452899]



“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨСЛИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИД

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

13330 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө, ШУА-ийн 1 дүгээр байр,
Утас: 45 28 94, Факс: (976-11) 45 28 99,
Вэбсайт: www.archaeology@mas.ac.mn

2023.08.28 № 01/311

танай _____-ны № _____-т

Археологийн малтлага судалгааны
ажил гүйцэтгэсэн тухай

Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах” тухай хуулийн хүрээнд ШУА-ийн Археологийн хүрээлэн нь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй байгуулсан Археологийн малтлага судалгааны ажлын гэрээ (АҮГ/2023/76 тоот)-ний дагуу 2023 оны 05 дугаар сарын 31-нээс 07 дугаар сарын 09-нийг дуустал 40 хоногийн хугацаанд Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сумын нутаг дахь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн барилга, бүтээн байгуулалтын талбайд орших археологийн 23 дурсгалын малтлага судалгааны ажлыг гүйцэтгэв. Үүнд: Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт хүрэл зэвсгийн үед холбогдох “Хиргисүүр ба буган хөшөөний соёл”-ын оршуулгын дурсгал 1 (С078), мөн хүрэл зэвсгийн үеийн булш 12 (С079, С080, С088-С096, С098), Ховд аймгийн Мянгад сумын нутагт хүрэл зэвсгийн үеийн булш 5 (В059, В060, В074, В082, В083), тахилын байгууламж 2 (В076, В076а), түрэгийн үед холбогдох тахилын байгууламж 1 (В075), агуй 1 (В220), Увс аймгийн Өмнөговь сумын нутагт нүүрс шатаах зуух 1 (А434) тус тус багтаж байна. Увс аймгийн Өмнөговь сумын нутагт хайгуулаар илэрсэн барилга, бүтээн байгуулалтын талбайд орсон нүүрс шатаах зуух буюу А434 дугаартай дурсгал бүтээн байгуулалтын автозамын трасст өртсөн тул судалгаанд хамрагдаагүй болно. Судалгаанд замын далан болон автозамд өртөж буй Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт орших С078, Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших В076а, В082 дугаартай дурсгалууд нэмж хамрагдав.

Археологийн малтлага судалгааны явцад С078 дугаартай оршуулгын чулуун хайрцаг, тахилын байгууламжтай хиргисүүрийн гадна чулуун хүрээний орчмоос Еврази төрлийн буган хөшөө шинээр илрүүлэв. Мөн С079 дугаартай битүү чулуун овоолготой дугуй хэлбэртэй хүрлийн үеийн булшнаас оршуулгын хос чулуун хайрцагт хүнээ оршоосон хос оршуулга илэрсэн нь Алтайн бүс нутгийн хэмжээнд анхны тохиолдол болж байна. Хос оршуулгын нэгд 30-35 насны холимог төрхийн эрэгтэй хүний яс илэрсэн бол нөгөө оршуулгаас хадгалалт муу, хүйс тодорхойлох боломжгүй 18-22 орчим насны хүний яс тус тус илрэв. Малтлага судалгаагаар С079, С080, С089, С090, С091, С092, С094, С095, В059, В060, В074, В082 дугаартай булшнаас хүний яс, С079, С080, С095, В060, В075, В082, В220 дугаартай дурсгалаас мал, амьтны яс бүрэн, бүрэн бус байдлаар илэрч олдсон нь палеоантропологи, зооархеологийн судалгааны Алтайн бүс нутгийн баялаг хэрэглэгдэхүүн болж дурсгалын он цагийг тогтоох, эртний хүн амын угсаа гарал, тархалт, шилжилт хөдөлгөөн зэрэг олон чухал мэдээллийг тодруулахад эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой юм.

Цаашид хүн, мал, амьтны ясны дээжид лабораторийн нарийвчилсан он цаг тогтоох судалгаа хийлгэхээр төлөвлөж байна.

Мөн С079 дурсгалаас хүрэл чимэглэл, ваар савны хагархай, С080 дурсгалаас нүхэлсэн сувс чимэглэл, В083 дурсгалаас ваар савны хагархай 10 ширхэг, В226 дурсгалаас ваар савны хагархай 4 ширхэг тус тус илэрч олдсон нь соёлын хамаарлыг тодорхойлох чухал хэрэглэгдэхүүн болж байна. Судалгаанд хамрагдсан булш оршуулгын дурсгалуудыг эрт цаг тонож сүйтгэсэн хэдий ч малтлагын үр дүнд дурсгалын гадаад, дотоод бүтэц зохион байгуулалтыг орчин үеийн дэвшилтэт технологи, багаж төхөөрөмжийн тусламжтай тодорхойлон баримтжуулав. В226 дурсгал буюу Хар Байцын агуйн малтлагаас ваар савны хагархай, мал, амьтны ясны үлдэгдэл цөөнгүй илэрсэн нь хүрэл зэвсгийн үе буюу түүнээс хожуу үеүдэд хүмүүс түр хугацаагаар, ан гөрөө хийх зорилгоор амьдарч байсныг гэрчилж байна.

Малтлага судалгааны зэрэгцээ Шижигтийн хавцлын адаг орчим, Ховд голын зүүн дэнж орчмоос чулуун зэвсгийн 40 орчим олдвор, чулуун залтас, үлдцийг сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулж, харьцуулсан судалгаагаар доод палеолитын төгсгөл үе (100 мянган жил)-ээс дээд палеолитын эхэн үе (40 мянган жил) хүртэлх хугацаанд хамаарахыг тодорхойлов. Чулуун зэвсгийн дурсгалт газрууд нь эртний хүмүүс амьдарч байсан ил суурины төрөлд хамаарч байна.


Бидний малтан шинжилсэн археологийн дурсгалууд нь он цагийн хувьд одоогоос 3500-3000 жил буюу хүрэл зэвсгийн үе, мөн VI-VIII зууны түрэгийн үед холбогдох бөгөөд урьд өмнө археологийн судалгаа харьцангуй бага явагдсан Алтайн бүс нутагт эрт цагаас хүн тасралтгүй оршин амьдарч байсан, оршуулгын өвөрмөц зан үйл, олон соёлын үйл явц бүрэлдэн тогтсон болохыг харуулах судалгаа болж чадсанаараа эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой юм.

Ийнхүү Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн хүрээнд Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумдын нутаг, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн барилга, бүтээн байгуулалтын талбайд илэрсэн археологийн 23 дурсгалын авран хамгаалах малтлага судалгааны ажлыг үр дүнтэй гүйцэтгэв. Барилга, бүтээн байгуулалтын ажлын явцад өгөгдсөн талбайд археологийн дурсгал өртөж сүйдэх аюулгүй болсныг мэдэгдэж байна.

Цаашид “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн төсөл хэрэгжүүлэх нэгж, усан сангийн талбайд археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг хуулийн хүрээнд гүйцэтгүүлэх, бүтээн байгуулалтын ажлын явцад анхаарал болгоомжтой ажиллах, аливаа нэгэн дурсгал, олдвор илэрсэн тохиолдолд зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэж, Соёлын биет өвийг хадгалан хамгаалах, судлах тал дээр хамтран ажиллахыг зөвлөж байна.

Жич: Малтлага судалгааны ажлын тайланг хавсаргав.


ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D),
ДЭД ПРОФЕССОР



Г.ЭРЭГЗЭН

D:/alban bichig/2022/alban bichig doc A4/

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн
2023 оны 08-р сарын 28-ны өдрийн
04/341 тоот албан бичгийн хавсралт



Археологийн дурсгалын мэдээлэл

№	Аймаг, сумын нэр	Нийт дурсгал	Тусгай хэрэгцээт талбайд илэрсэн дурсгал	Барилга, бүтээн байгуулалтын талбайд малтан судалсан дурсгал
1	Увс, Өмнөговь	833	644	1 (автозамд орсон)
2	Ховд, Мянгад	220	219	9
3	Ховд, Эрдэнэбүрэн	98	96	13
4	Баян-Өлгий, Баяннуур	970	965	-
	Нийт	2121	1924	23

-----oOo-----

БАТЛАВ.
“ЭРДЭНБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ” ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

..... Ч.САРАНЖАВ



БАТЛАВ.
“ТӨКОЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

..... Т.МӨНХЖАРГАЛ



БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 08 сарын 08 өдөр

№... АУТ-2023/86 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Төмөрчний гудамж, 22 байр 19 тоотод байрлах “Төкол” ХХК /РД: 2618338/ (цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж Захирал Т.Мөнхжаргал, нөгөө талаас ХУД, 19 хороо, Тайж групп оффисийн 201 тоот байрлах “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” /РД:9922431/ төслийн Зохицуулагч Ч.Саранжав (цаашид “Захиалагч” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГОЛ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүсэлтийн дагуу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөл хэрэгжих Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт баригдах төслийн түр замын трассийн дагуу холбогдох хууль, журам, аргачлал, стандартад нийцсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх түүнтэй холбогдон гарах эрх үүрэг, хариуцлага, төлбөр тооцоотой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг /БОТБУ/ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журам, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх журам, аргачлал, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.3. Гүйцэтгэгч нь холбогдох судалгаа, шинжилгээ хийж, эдгээрийн үр дүнг боловсруулан үнэлгээний тайлан бичнэ. Тус үнэлгээний тайлан нь хууль журамд заагдсан шаардлагыг бүрэн хангасан байна.
- 1.4. Гүйцэтгэгч нь байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй байна.
- 1.5. Гэрээний Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болсонд тооцож ажил гүйцэтгэх хугацаа эхэлнэ.
- 2.2. Ажлыг гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 30 хоногт хийж гүйцэтгэнэ.
- 2.3. Ажлын онцлог, нөхцөл байдлаас шалтгаалан судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх хугацааг сунгах шаардлага гарвал гэрээний үндсэн хугацаа дуусгавар болохоос өмнө талууд харилцан тохиролцож хугацааг сунгаж болно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ


- 3.1.1. Гүйцэтгэгчийн хийх ажлын нийт үнэ 18,960,000.00 / Арван найман сая ёсөн зуун жаран мянган/ төгрөг байна (НӨАТ орсон).
- 3.2. Захиалагч тал гэрээ байгуулснаас хойш 3 хоногийн дотор төлбөрийн 70% -ийн урьдчилгааг гүйцэтгэгчид төлнө.

мэдээлэл, өрийн бичгийн хэмжээ, төлбөр тооцоо, байгууллага хувь хүн, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, нууцыг хугацаагүй хадгална.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж

Гүйцэтгэгч талыг төлөөлж


..... Ж.ЛУВСАНДАНДАР
“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”
төслийн Ерөнхий инженер


..... Т.МӨНХЖАРГАЛ
“Тэкол”ХХК-ийн Захирал

Хаяг: ХУД, 19 хороо, Тайж групп оффисийн 201
тоот

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
3-р хороо, Төмөрчний гудамж, 22 байр 19
тоот



ХОВД АЙМАГ
ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГА

84180 Хар ус, Эрдэнэбүрэн сум, Ховд аймаг

2023.06.30 № 1/133

танил _____ -ны № _____

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД

Эрдэнэбүрэн сумын УЦС-ын төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд Шургийн гүүрнээс Шижигтийн хавцал хүртэлх 35 км түр зам тавих замын трасс нь Таван толгой, Өвдөг, Улиастайн гол зэрэг голуудад гүүр тавигдах, малын бэлчээрийн тоосжилтонд өртөх нь бага учир сум орон нутагт үр өгөөжтэй гэж үзэж байна.

Иймд технологийн түр замын трассыг дэмжиж байгаагаа үүгээр мэдэгдье.

Хувийг: Эрдэнэбүрэн сумын УЦС-ын төслийн нэгжид



У.ЦЭРЭНТОГТОХ

84180 04 176

БАТЛАВ.
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Э. БОЛОРМАА

**“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ” ХЭРЭГЖИХ “ХОВД АЙМГИЙН
ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН НУТАГТ БАРИГДАХ ТҮР ЗАМ”-ЫН ДАГУУХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 07 сарын 06 өдөр

Ховд хот

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Шижигтийн хавцалд хэрэгжих бөгөөд төслийн зорилго нь Баруун бүс нутгийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах, баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж, өртөг багатай эх үүсвэрээс бүс нутгийн эрчим хүчний дутагдлыг нөхөж ОХУ-ын цахилгаан эрчим хүчний импортын хамаарлаас гарахад чиглэж байна.

Төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 357 тоот тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд 28000 га газрыг авсан бөгөөд Ховд аймгийн Эрдэнэбүрэн болон Мянгад сум, Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум гэсэн 3 аймгийн 4 сумын нутаг дэвсгэр хамарч байна.

Ховд гол дээр УЦС барих төслийн урьдчилсан судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажил 1964 оноос эхлэн хэд хэдэн удаа хийгдэж ирсэн ба Монгол Улсын Засгийн газраас “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” төслийг хэрэгжүүлэх нь эрчим хүчний бие даасан байдалд нөлөөлөх чухал том алхмын нэг гэж үзэн БНХАУ-ын Усны нөөцийн хайгуул, зураг төсөл, судалгааны “Бэйфан компани” ХХК-иар “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийг барих ТЭЗҮ-г боловсруулж баталгаажуулсан.

Эрдэнэбүрэнгийн УЦС ашиглалтад орсноор:

- Баруун бүсийн эрчим хүчний системд ЦЭХ үйлдвэрлэн нийлүүлж Орос улсаас импортоор авч буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах
- Тухайн бүс нутгийн дэд бүтцийг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Татварын орлогыг нэмэгдүүлснээр Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөнжлийг дэмжих
- “Бүс ба зам” хамтын ажиллагааг бэхжүүлж, Хятад Монголын уламжлалт найрамдлыг бэхжүүлэх болно.

1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх үндэслэл

Монгол улсын нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нь 2022 оны байдлаар 8,178.6 сая кВт*цаг байсан байна. Үүнээс сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь буюу Нар, Салхи, Усны үйлдвэрлэсэн эрчим хүч 9.2 хувь байгаа ба 0.8 хувийг усан цахилгаан станцаас үйлдвэрлэсэн байна. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний (ЦЭХ) жилийн өсөлт 2008-2022 онуудад жилд дунджаар 8-10 хувийн өсөлттэй байна. Жилээс жилд өсөн нэмэгдэж

байгаа ЦЭХ-ний хөрөглөөг хангахын тулд цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд буюу нөхөн сэргээгддэг эх үүсвэрүүдийг ашиглан ЦЭХ үйлдвэрлэдэг станцуудыг шинээр барьж байгуулах шаардлага улам бүр өссөөр байна. ЦЭХ нөхөн сэргээгддэг эх үүсвэрүүдээс гарган авах нь орчин, байгаль цаг уурт нөлөөлөх нөлөөллийг хамгийн бага байлгах ирээдүйн өнгө төрхийг тодорхойлох юм.

Манай улсын хувьд Баруун бүсийн эрчим хүчний системийн тасралтгүй өсөлт, бие даасан байдал, аюулгүй ажиллагаа, цэвэр усны хуримтлал, горим тохируулга зэргээрээ “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлага бий болоод байгаа. Төслийг хэрэгжүүлэх үндэслэлийн гол хүчин зүйлүүд нь:

- Баруун бүсийн эрчим хүчний системийн хэрэглээ жил дунджаар 8-11%-иар өсч байна.
- Баруун бүс нь цахилгаан эрчим хүчний хэрэглээнийхээ 81.4%-ийг ОХУ, болон БНХАУ-аас, 12.1%-ийг “Дөргөн УЦС”, 6.5%-ийг Ховд нар НЦС хангаж байгаа нь импортын эрчим хүчний хараат байдалтай байна.
- Хүнд болон хөнгөн үйлдвэр, уул уурхайн ордуудыг ашиглахад цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүд нэн шаардлагатай байдаг.

Баруун Бүсийн Нэгдсэн Системийн (ББНС) цахилгаан эрчим хүчний (ЦЭХ) өсөлт нь сүүлийн жилүүдэд ихээр өсөн нэмэгдэж байгаа Баруун Бүсийн Нэгдсэн Системийн (ББНС) цахилгааны хэрглээ 2022 онд 238.2 сая кВт*цаг болж өмнөх оноос 22.2 сая кВт*цаг буюу 10.3%-иар өсөлттэй байна. Монгол улсын хэмжээнд хамгийн томоохон төслийн нэг нь “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” юм. Энэхүү төсөл нь ББЭХС-ийн тасралтгүй өсөлт, бие даасан байдал, аюулгүй ажиллагааг хангах, цэвэр ус хуримтлуулах, горим тохируулгын үүрэг гүйцэтгэх томоохон усан цахилгаан станц юм.

2. Ажлын зорилго

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн хүрээнд Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт баригдах 35км орчим урттай түр зам барих замын чиглэл (трасс)-ийн дагуу Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн дагуу Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) хийх ба Байгаль орчны ерөнхий үнэлгээг (БОЕҮ)-г Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газар хийж гүйцэтгэх болно.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”- нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт баригдах 35км орчим урттай түр зам барих төслийн Байгал орчны төлөв байдлын үнэлгээг (БОТБҮ) хийх Монголын Зөвлөх компаниудын хүсэлтийг зүй ёсоор хүлээн авч, гэрээ байгуулах болно.

3. Ажлын цар хүрээ

Зөвлөх нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт баригдах 35км орчим урттай түр зам барих төслийн Байгал орчны төлөв байдлын үнэлгээний (БОТБҮ) тайланг боловсруулж Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газраар батлуулах үүрэг хүлээнэ.

Байгал орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) нь дараах нөхцөлийг хангасан байна.

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль (1998,2012 онд нэмэлт өөрчлөлт орсон) болон БОАЖЯ-аас гарын авлага, холбогдох бүх шаардлагуудыг дагаж мөрдөх ба түүнийг хэрэгжүүлэх
- Тус төслийн байгаль орчны мэдээлэлд физикийн, биологийн, нийгэм эдийн засгийн өгөгдлүүдийн зам дайрах газруудын тайлбарыг ямар нэг хязгаарлахгүйгээр оруулах, Үүнд:
 - Геологи, байр зүй ба хөрсний
 - Газар ашиглалтын
 - Гадаргын ба гүний усны нөөц, болон үерийн эрсдэл
 - Агаарын чанар
 - Дуу чимээний үнэлгээ
 - Газар хөдлөлтийн ба гамшгийн эрсдэлийн үнэлгээ
 - Уур амьсгал (температур, хур тунадас, салхи г.м – Ургамал ба амьтны аймаг, ховор ба нэн ховор төрөл, зүйлүүд байгаа бол заавал оруулна)
 - Тусгай хамгаалалттай ба Дархан цаазат газар нутгууд
 - Нийгэм эдийн засгийн байдал (хүн ам, ДНБ, боловсрол, явуурал, хөдөлмөр эрхлэлт ба дэд бүтэц зэрэг гол үзүүлэлтүүдийг багтаана)
 - Эмзэг хэсгүүд буюу түүх соёлын биет өвүүд

Байгал орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) нь эмзэг идээшил нутаг дэвсгэрт хэрэгжихдээ төлөвлөж байгаа төслийн үйл ажиллагаатай холбогдуулж

- (i) аливаа эмзэг идээшил нутаг бүхий орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодруулах
- (ii) аливаа ховор эсвэл нэг ховор төрөл зүйлүүдийн тоо толгой байгааг тогтоох
- (iii) аливаа бага зэргийн нөлөөллүүдийг тодруулахаар байхыг тус тус батлан даана.
- Хэрэв төслийн нутаг дэвсгэр хуулиар хамгаалагдсан газар нутагт орж байвал БОТБҮ-нд тухайн хамгаалагдсан нутаг дэвсгэрийн хамгаалалтанд тавигдсан газруудыг тодруулан оруулах
- Хэрэв зайлшгүй гэж үзвэл Дэлхийн банкны бүлгийн Байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны зааварчилгаа зэрэг олон улсад танигдсан стандартуудыг тусгасан бохирдолоос урьдчилан сэргийлэх болон хянах технологиудыг БОТБҮ-нд ашиглах ёстой.
- Зөвлөх нь БОАЖЯ-тай илүү ойр дотно зөвлөлдөх ба ингэхдээ БОАЖЯ-ны заавар зөвлөмж болон саналууд үр нөлөөтэйгээр төсөлд тусгагдаж байгаа эсэхийг дааж ажиллах мөн БОТБҮ хийхэд БОАЖЯ-ны холбогдох зөвшөөрлийг авч ажиллах чадвартай нэгэн байх ёстой.

4. Тусгай зөвшөөрөл – Шаардана.

5. Зөвлөхөд тавигдах шаардлага

- 5.1 Төслийг гүйцэтгэх зөвлөх нь БОАЖЯ-нд бүртгэлтэй ба БОБНҮ хийх зөвшөөрөл авсан Монгол Улсын зөвлөх коспани байна.
- 5.2 Тухайн зөвлөх компани оролцох хүсэлт гарган гэрээ байгуулсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд холбогдох зөвшөөрөл нь хүчинтэй байх

5.3 Зөвлөх компаниуд нь Монгол улсад дахь эрчим хүчний салбарт БОБНҮ явуулж байсан туршлагатай байх ёстой. Олон улсын байгууллага,(ДБ, АХБ, бусадтай хамтарч ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.)

6. Ажлын хуваарь

- 6.1 Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн дагуу, БОТБҮ-ний ажлыг гэрээний нөхцөл хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш ажлын 25 хоногт гүйцэтгэнэ.
- 6.2 БОТБҮ-ний эцсийн тайланг ажил дууссанаас хойш 7 хоногт багтаан Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 6.3 БОТБҮ-ний тайланг боловсруулж Захиалагчаас санал авах
- 6.4 Байгаль орчны ерөнхий үнэлгээг (БОЕҮ)-г Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газраар батлуулж БОБ-ийн Ерөнхий үнэлгээг хийлгэнэ.
- 6.5 БОАЖЯ-наас заавар зөвлөмж хүлээн авсан бол түүнээс хойш 2 долоо хоногийн дотор БОТБҮ-г эцсийн байдлаар боловсруулсан байх шаардлагатай.

Хянасан: АЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч



Б.Баярсүх

ХБТХОХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч




Б.Түмэндэмбэрэл

Боловсруулсан: ХБТХОХ-ийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч



Н.Цацралцэцэг

БАТЛАВ:


ЗАХИАЛАГЧ
ЭРДЭНЭБҮРЭНГИЙН
УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ
(Гарын үсэг)
9522431 У.СБ/104
УЛААНБААТАР

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”
төслийн Зохицуулагч
Ч.Саранжав


ГҮЙЦЭТГЭГЧ
ХӨДӨӨ АЖ АХУЙН
УЛААНБААТАР ХОТ
НАТУРАЛ РЕСУРС
АНД АМЬСГАЛ
ЭКОНОМИКС
(Гарын үсэг)
ТТ37326 ☎ 8103933
ХҮРЭЭЛЭН НҮТЭБ

“Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Энх-Амгалан

**ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ХАМААРАХ
АЙЛ ӨРХИЙН ИРГЭН БҮРТ ОЛГОХ НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ, ҮР
НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА ХИЙХ ГЭРЭЭ**

Дугаар № АҮГ-2023/82


Нэг талаас *Эрчим хүчний яам*, “*Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц*” төсөл (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 05 сарын 22-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав. Үүнд:


1. **Үйлчилгээ**
 - 1.1. Зөвлөх нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан ажил үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
 - 1.2. Зөвлөх нь үйлчилгээг үзүүлэхдээ Хавсралт 2-т тодорхойлсон “Зөвлөхийн ажиллах хүчний жагсаалт”-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.
 - 1.3. Зөвлөх нь Хавсралт 3-т тодорхойлсон “Зөвлөхийн тайлан гаргах хуваарь”-т заасан маягтаар, түүнд товлосон хугацаанд тайлангууд гаргаж захиалагчид ирүүлнэ.
2. **Хугацаа**
 - 2.1. Зөвлөх нь үйлчилгээг **2023 оны 05 сарын 25-аас 06 сарын 25 -НЫ** хооронд, эсхүл талуудын бичгээр харилцан тохиролцсон хугацаанд гүйцэтгэнэ.
3. **Төлбөр**
 - 3.1. Төлбөрийн дээд хэмжээ.


Захиалагч нь зөвлөхөд Хавсралт 1-ийн дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөрт төлөх дээд хэмжээ нь **20 000 000 төгрөг** болно. Энэ дүнд зөвлөхийн бүх зардал, ашиг, мөн түүнчлэн зөвлөхөд ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно.

захиалагчийн өмч болж үлдэнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.

- | | |
|--|---|
| 8. Зөвлөх зарим нэг үйл ажиллагаанд оролцохгүй байх | 8.1. Зөвлөх, түүний нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь энэ гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш энэ үйлчилгээнээс үүсэлтэй, эсхүл түүнтэй нягт холбоотой аливаа төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэ үйлчилгээ болон түүний үргэлжлэлээс бусад)-ний гүйцэтгэгчээр ажиллах эрхгүй болохыг зөвлөх хүлээн зөвшөөрч байна. |
| 9. Даатгал | 9.1. Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна. |
| 10. Эрх шилжүүлэлт | 10.1. Зөвлөх нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй. |
| 11. Гэрээнд мөрдөх хууль ба хэл | 11.1. Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь монгол хэл байна |
| 12. Маргааныг шийдвэрлэх | 12.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ. |

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Б. Мөнхтүлгэ
(Гарын үсэг)
Чин захиалагчийн албан дарга
(Албан тушаал)

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

З. Жамбал
(Гарын үсэг)
ЗАХИРАЛ
(Албан тушаал)




ХАВСРАЛТ

- Хавсралт 1: Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ
- Хавсралт 2: Зөвлөхийн ажиллах хүчний жагсаалт
- Хавсралт 3: Зөвлөхийн тайлан гаргах хуваарь.

Батлав:
“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” ТХН
Төслийн зохицуулагч

..... Ч.Саранжав



Батлав:
“Ай Эй Пи Инсайт” ХХК-ийн
Захирал:

..... Б.Золзаяа



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 он 09 сар 11 өдөр

№ АҮГ-2023/87

Улаанбаатар хот

Энэхүү ажил үйлчилгээний гэрээ /Цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас: Регистрийн №9922431 “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл” түүнийг төлөөлж Төслийн нэгжийн Зохицуулагч албан тушаалтай Ч.Саранжав (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас: Улсын бүртгэлийн 9011330035, Регистрийн №6363334 дугаартай “Ай Эй Пи Инсайт” ХХК, түүнийг төлөөлж Захирал албан тушаалтай Б.Золзаяа (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурласан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ. Нийтлэл үндэслэл

1.1 Гэрээний зорилго:

1.1.1 Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалга, зааварчилгаа болох “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн нөлөөлөлд өртөж буй иргэдийн төлөөллийг “Тайширын УЦС”, “Дөргөний УЦС”-ын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг гүйцэтгэх /цаашид “гэрээт ажил” гэх/ Захиалагч нь уг ажлын шаардлага хангасан үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөхтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2 Гэрээний хавсралтууд:

- 1.2.1 Дараах бичиг баримтуудыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:
- 1.2.2 Хавсралт 1: Ажлын даалгавар
- 1.2.3 Хавсралт 2: Ажлын хөтөлбөр
- 1.2.4 Хавсралт 3: Ажлын төсөв

ХОЁР. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл

2.1 Гэрээний үнэ

- 2.1.1 Гэрээний нийт үнэ: 18,584,874₮ (Арван найман сая таван зуун наян дөрвөн мянга найман зуун далан дөрөв) төгрөг (НӨАТ орсон дүн) байна.
- 2.1.2 Гэрээний үнийн задаргааг Хавсралт №3 –д заасан болно.
- 2.1.3 Гэрээний үнэ гэрээний хүчинтэй хугацаанд тогтмол байна.

5.5.4 Гэнэтийн болон давтагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэнийг эрх бүхий байгууллага /МҮХАҮТ/ нотолсон байвал зохино.

5.6. Нууцыг хадгалах

- 5.6.1 Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 5.6.2 Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд и-мэйл хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.
- 5.6.3 Энэхүү гэрээний 1.2-т заасан хавсралт болон бусад бичиг баримтууд дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзнэ.
- 5.8.4 Гэрээ болон түүний хэрэгжилттэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараах албан ёсны хаягаар хүргүүлнэ. Үүнд:

Захиалагч:	“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”
Хаяг:	Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Тайж группийн байр 201 тоот
Утас:	77551516, 89013368
И-мэйл:	info@erdeneburenhpp.mn
Холбогдох албан тушаалтан:	Гэрээ хэлцэл, нийгмийн асуудал хариуцсан ажилтан М.Бямбасайхан
Гүйцэтгэгч:	“Ай Эй Пи Инсайт” ХХК
Хаяг:	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, SAV тауэр, оффис 308 тоот
Утас:	99039110
Холбогдох албан тушаалтан:	Гүйцэтгэх захирал Б.Золзаяа

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

Захиалагч талыг төлөөлж:

БАТЛАВ: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”-ын Гэрээ хэлцэл, нийгмийн асуудал хариуцсан ажилтан


/М.Бямбасайхан/

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

БАТЛАВ: “Ай Эй Пи Инсайт” ХХК-ийн захирал


/Б.Золзаяа/

БАТЛАВ:
“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН ЗОХИЦУУЛАГЧ



УЛААНБААТАР ХОТ

/Ч.САРАНЖАВ/

БАТЛАВ:
МОНГОЛЫН БАРИМТАТ КИНО, ГЭРЭЛ
ЗУРАГ, ДУУ АВИАНЫ ҮНДЭСНИЙ
НИЙГЭМЛЭГИЙН ЗАХИРАЛ



Д.ЭНХТӨР/

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар АУГ-2023/88

Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ цаашид “Гэрээ” гэх-г Монгол Улсын Иргэний хуулийн 476-480 дугаар зүйлүүдийг үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо Монголын баримтат кино, гэрэл зураг, дуу авианы үндэсний нийгэмлэг /РД: 1090399/ (цаашид “ажил гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж захирал Д.Энхтөр, Нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 1-р хороо, Зайсангийн гудамж “Тайж” группын байр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн төлөөлж төслийн зохицуулагч Ч.Саранжав цаашид “захиалагч” хамтад нь “талууд” гэх нар дараах нөхцлүүдийг харилцан тохирцож, энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

1.1 Энэхүү гэрээгээр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн олон нийтэд усан цахилгаан станцыг таниулах соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэх нэвтрүүлэг хийх,

1.2 Усан цахилгаан станцыг олон нийтэд сурталчилах нэвтүүлэгийн бэлтгэх ажлыг Ховд аймгийн Мянгад Эрдэнэбүрэн сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Увс аймгийн Өмнөговь сумын иргэдийн төлөөлөл Тайшир, Дөргөний усан цахилгаан станцтай танилцах ажлыг сурвалжлах, усан цахилгаан станцын ашиг тусыг сурталчилах нэвтрүүлэг бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, НӨХЦӨЛ

2.1. Гэрээний үнийн дүн 15,000,000 сая төгрөг / Арван таван сая төгрөг байна/

2.2. Эрдэнэбүрэнгийн төсөл нь Гэрээний 2.1 заасан үнийн дүнг 2 хуваан шилжүүлнэ. Зураг авалтын бэлтгэл ажилд урьдчилгаа 90% болон нэвтрүүлэг хүлээн авсны дараа үлдсэн 10%-ийг шилжүүлнэ.

2.2.1. Эрдэнэбүрэнгийн төсөл нь бүрэн хэмжээний нэвтрүүлэг хүлээн авсны дараа үлдэгдэл төлбөрийг шилжүүлнэ.

2.2.2. Банкны мэдээлэл

9.2 Гэрээний нөхцөлд талуудын харилцан тохиролцсоноор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд орох нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулан гэрээнд хавсаргана.

9.3 Нэмэлт өөрчлөлт хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд түүнтэй нэгэн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ:


Эрдэнэбүрэнгийн УЦС-ын албаны дарга



..... Б.Мөнхтулга

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:

Монголын баримтат кино, гэрэл үйл ажиллагааны зураг, дуу авианы үндэсний нийгэмлэгийн захирал



..... Д.Энхтөр

Хаяг:

Хан-Уул дүүрэг 19-р хороо, Зайсан, Богд Жавзандамбын гудамж, Тайж группын байр, 201 тоот

Хаяг:

Цахим хаяг: enkhtur@yahoo.com
Гар утас: 99161939